

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ,
АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХТУХАЙ 2023 ОНЫ
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ**

Энэхүү гэрээг нэг талаас Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Засаг дарга (цаашид “Засаг даргын орлогч” гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “ЭС ЖИ ГРУПП” ХХК (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээгээр талууд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой хэвийн явуулах чиглэлээр хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших Баян-Өлгий аймаг Цэнгэл сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

1.3. Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Татварын тухай болон бусад хууль тогтоомж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон холбогдох шийдвэрүүдийн хүрээнд явагдана.

ХОЁР. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

2.1.2. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах;

2.1.3. Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх;

2.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

2.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

2.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид хөдөлмөр эрхлэх хүсэлтэй орон нутгийн иргэдийг бүртгэх, зохион байгуулах, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс тавьсан шаардлагад нийцсэн иргэдийг санал болгох.

2.1.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардлагатай байгаа ажлын байрны жагсаалтыг ирүүлсэн тохиолдолд ажлын байрны жагсаалт түүнд тавигдах шаадлагыг орон нутгийн иргэдэд хүртээмжтэй зарлах.

2.1.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх.

ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн төрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

3.1.3. Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;

3.1.4. Нийт ажлын байрны 60-аас доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах;

3.1.5. Компани нь тусгай мэргэжил шаардахгүй ажлын байрыг нэн тэргүүнд үйлдвэр, уурхай байрлаж буй сумын иргэдэд санал болгох,

3.1.6. Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум, дүүрэг)-ийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх;

3.1.7. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох;

3.1.8. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;

3.1.9. Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх.

3.1.10. Монгол Улсын хуулийн дагуу орон нутгийн албан татварыг тайлагнаж Цэнгэл сумын төсвийн орлогын дансанд төвлөрүүлж, татварын өр төлбөргүй ажиллана.

3.1.12. Ажиллагсдыг хууль тогтоомжид заагдсан даатгалд бүрэн хамруулна.

3.1.13. Уул уурхайн болон боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг сум, орон нутгийн иргэдэд сурталчилна.

3.1.14. Орон нутгийн бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, мал услах цэгүүдийг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлж ажиллана.

3.1.15. Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон тайланг олон нийтэд танилцуулж, нутгийн иргэдийг мэдээллээр хангах ажлыг тухай бүр нь төсөл хэрэгжиж байгаа сумын Засаг даргатай хамтран зохион байгуулж ажиллана.

3.1.16. Уулын ажлын болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэн орон нутагт актаар хүлээлгэн өгнө.

3.1.17. Аймаг сумдын төрийн байгууллагууд, нутгийн иргэдийг үйлдвэр, уурхайн байгаль орчны үйл ажиллагаатай танилцуулах ажлыг орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

3.1.18. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагддаг агаар, ус, хөрсний шинжилгээг Баян-Өлгий аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны лабораториар жилд 1-ээс доошгүй удаа хийлгэнэ.

3.1.19. Ашигт малтмал, бүтээгдэхүүн тээвэрлэлтийн тодорхой хэсгийг орон нутгийн жолооч аж ахуйн нэгжээр хийлгэж болно.

3.1.20. Орон нутгийн аж ахуйн нэгжийн санал болгосон бараа нь компанийн "Бараа, материал худалдан авах шалгуур үзүүлэлт" болон үйлдвэрлэлийн хэрэгцээ, зориулалт, шаардлага, чанарын үзүүлэлтийг хангаж байгаа тохиолдолд дэмжиж ажиллана.

3.1.21. Гамшиг, осол, гал түймэр гарсан үед сайн дурын үндсэн дээр тухайн сум, орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний туслалцаа дэмжлэгийг үзүүлнэ. ,

ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД САНХҮҮЖҮҮЛЭХ АЖЛУУД

4.1. Цэнгэл сумын ЗДТГ-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эс Жи Групп" ХХК нь дараах ажлыг санхүүжүүлнэ. Үүнд:

- Засаг даргын Тамгын газрыг унаатай болгох. 30,0 сая төгрөг
- Зам гүүр /Ховд голын модон гүүр, Бейтсайн гүүр/засварын ажил 10,0 сая

2023 оны хамтран ажиллах гэрээний нийт дүн 40,0 сая төгрөг байна.

4.2. Гэрээний санхүүжилтийг дансаар шилжүүлэх бөгөөд худалдан авах болон бусад үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл эзэмшигч оролцохгүй.

4.3. Худалдан авах ажиллагаа болон засварын ажлыг ЗДТГазар зохион байгуулна.

ТАВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХОРОО

5.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

5.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.

Гэрээний хэрэгжилтийг хянах, үнэлгээ хийх болон төслийн талаарх Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон орон нутгийн иргэдийн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх зорилгоор Хороо нь хагас жил тутамд хуралдана.



5.3. Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

6.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ болон түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна.

Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг (сум, дүүрэг)-ийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

6.2. Талууд гэрээний биелэлтийг жилд нэг удаа дүгнэх ба Засаг дарга тайланг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

6.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

7.1. Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

7.2. Энэхүү гэрээг биелүүлэхэд хоёр тал санаачилга гаргаж ажиллана.

7.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

7.4. Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

7.5. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

8.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

ЕС. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

9.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

9.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно. Энэ тухайгаа нэг сарын өмнө нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.

9.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.4. Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарвал нөгөө талдаа 30 хоногийн өмнө харилцан бичгээр мэдэгдэнэ. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.



9.5. Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЦЭНГЭЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Ш.НАСИХАТ(.....)

(эцэг/эх-ийн нэр, нэр, гарын үсэг)
тамга, тэмдэг)




ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ
КОМПАНИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.СОДНОМПИЛ

(.....)

(эцэг/эх-ийн нэр, нэр, гарын үсэг,



ХАРИЛЦАН ЗӨВШӨӨРСӨН:

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ш.НАСИХАТ

УУРХАЙН ДАРГА)

